



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/2021

Мандалговь

Аймгийн 2021-2024 оны Стратеги  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмын"-ын 2.1, 2.2, 2.3, 3.1 дэх заалтууд аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг орон нутагт оновчтой зохион байгуулах зорилгоор ажлын хэсгийн боловсруулсан "Аймгийн 2021-2024 оны Стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Аймаг болон салбарын стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагууд тус бүр чиг үүргийн дагуу стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусган, явцын үр дүнг жил бүр тайлагнаж ажиллахыг төсвийн шууд захирагч, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2 жил тутамд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481210562